



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ



АЖЛЫН ТАЙЛАН
(2020-2024)

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН





Мэндчилгээ

Эрхэм хүндэт Төлөөлөгч нөхдийнхөө энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье.

2020 оны Орон нутгийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүрэн эрхийн хугацаанд 27 удаа хуралдаж, 105 тогтоол шийдвэрийг баталлаа.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2020-2024 оны сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ойртуулах, Хурлын байгууллагын ил тод, нээлттэй, шуурхай байдлыг хангаж, иргэдээ дээдэлсэн, өрхийн хөгжлийг дэмжсэн, бие даасан эдийн засагтай, ногоон хөгжил бүхий дүүрэг болох зорилтыг дэвшүүлэн бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Дэвшүүлсэн зорилтынхоо хүрээнд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нутгийн захиргааны байгууллагаас Төр засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, эрүүл мэнд, боловсрол, урлаг соёлын үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй хүргэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар иргэн бүрийг ажилтай, орлоготой болгох, иргэдийнхээ эрүүл аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламж, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр салбар бүрт үр дүн бүхий бүтээлч ажлуудыг дүүргийнхээ онцлогт нийцүүлэн хийж хэрэгжүүллээ.

Бид өнгөрсөн хугацаанд дэлхий нийтэд тархсан ковид-19 цар тахлын улмаас эрүүл мэнд, боловсролын салбар дахь удааширсан болон царцсан хөрөнгө оруулалт, тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхэд онцгой анхаарч ажиллалаа.

Цаашид бидэнд батлагдсан төсөв, хөрөнгө оруулалтаа бодит ажил болгохын тулд цаг наргүй хөдөлмөрлөж, дүүрэг орон нутгаа хөгжүүлэхээр төлөвлөсөн олон ажлууд байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Дүүргийнхээ хөгжлийн төлөө сэтгэл оюунаа зориулан ажилласан Хурлын Төлөөлөгчид, нутгийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчид, дэмжиж ажилласан дүүргийнхээ нийт иргэд та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлж, сайн сайхныг хүсэн ерөөе.

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
БҮЛТЭНХҮҮГИЙН МӨНХБАТ



1

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 27 удаа хуралдаж, 105 тогтоол шийдвэрийг баталлаа.

2

Дүүргийн хэмжээнд анхан шатны 24 хороо төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна.



3

Чингэлтэй дүүрэг 30 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлэв.



4

Дүүргийн Төлөөлөгчдийн дэргэд Төлөөлөгчдөөс Эмэгтэйчүүдийн ажиллаж байна.

иргэдийн Хурлын эмэгтэй бүрдсэн Зөвлөл



5

Дүүргийн Төрийн өмчийн 38 цэцэрлэгт Аймбрик, Стийм, Монтессори олон улсын хөтөлбөрүүд хэрэгжиж байна.



6

Дүүргийн хэмжээнд “Чингэлтэйд үйлдвэрлэв” байнгын борлуулалтын 4 цэг ажиллаж байна.



7

Хашаандаа мод тарья аян амжилттай хэрэгжиж байна.



8

Чингэлтэй дүүрэг камерын хяналттай, ногоон бүс боллоо.



9

Чингэлтэй дүүрэг Япон Улсын Яйзү хоттой гамшиг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.



ХУРЛЫН ХУРАЛДААН



ХУРАЛДААНЫ ТОО 27

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ 73

БАТАЛСАН ШИЙДВЭР 105

ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:

- Дүүргийн хүн амын нягтрал ихтэй 7, 12, 16, 17, 19 дүгээр хороодыг хувааж 20, 21, 22, 23, 24 дүгээр хороодыг шинээр байгуулав.
- Нийслэлийн Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэв.
- Чингэлтэй хайрхан уулын салбар уулс орчмын хилийн цэсийн солбицлыг шинэчлэн тогтоож, нийт 2.784.57 га газрыг газрын кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулав.
- Гамшгийн эрсдлийг бууруулах Чингэлтэй дүүргийн зөвлөлийг байгуулав.
- Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд Эмэгтэйчүүдийн Зөвлөлийг байгуулав.
- Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоов.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД:

- Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Гэр бүл 2024 арга хэмжээ;
- Соёлтой иргэн 2024 арга хэмжээ;
- Чадварлаг багш 2024 арга хэмжээ;
- Эрүүл Чингэлтэйчүүд 2024 арга хэмжээ;
- Бүтээлч Чингэлтэйчүүд 2024 арга хэмжээ;
- Ногоон дүүрэг 2024 арга хэмжээ;
- Чингэлтэйд үйлдвэрлэв арга хэмжээ;
- Хүний нөөц, нийгмийн баталгаа 2024 арга хэмжээ;
- Гамшиг осол, гал түймэрээс урьдчилан сэргийлэх 2024 арга хэмжээ;

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид бүрэн эрхийн хугацаанд 30 удаа хуралдаж, 40 асуудал хэлэлцэн, 86 тогтоол шийдвэрийг баталж, Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллалаа.



ХУРАЛ ДАХЬ МАН БҮЛЭГ

Хурал дахь намын бүлгийн Төлөөлөгчдөд зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий бүлгийн Ажлын алба ажиллаж байна.



ХУРЛЫН ЗӨВЛӨЛ



Хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Зөвлөл 2022 оноос шинээр байгуулагдан ажиллаж байна.

ХУРАЛДААНЫ ТОО **33** | ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ **90** | БАТАЛСАН ШИЙДВЭР **21**

ЭРХ ЗҮЙ, НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖЛИЙН ХОРОО:

ЧИГ ҮҮРЭГ: Эрх зүйн бодлого, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн хэрэгжилт, гэмт хэрэг, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх бодлого үйл ажиллагаа, гадаад, дотоод харилцаа, төрийн захиргааны байгууллагын удирдлага, зохион байгуулалтад хяналт тавих

Хуралдааны тоо **18** Санал дүгнэлт **22**

ТӨСӨВ САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХОРОО:

ЧИГ ҮҮРЭГ: Дүүргийн төсөв, санхүү, татварын бодлого үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гадаадын зээл тусламжийн бодлого, орон нутгийн өмчийн харилцаанд хяналт тавих

Хуралдааны тоо **21** Санал дүгнэлт **16**

ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ХЯНАЛТЫН ХОРОО:

ЧИГ ҮҮРЭГ: Дүүргийн төсвийн зарцуулалт, түүний гүйцэтгэл, Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, дотоод аудитын үйл ажиллагаанд хяналт тавих

Хуралдааны тоо **12** Санал дүгнэлт **11**

НОГООН ХӨГЖИЛ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ХӨГЖЛИЙН ХОРОО:

ЧИГ ҮҮРЭГ: Байгаль орчин, ногоон байгууламж, экологийн асуудал, хог хаягдлын менежмент, газрын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих


Хуралдааны тоо **10** Санал дүгнэлт **12**



Дарга: Х.Алтаншагай,
Гишүүд: Д.Ядамжав, З.Бямбажав,
Н.Батсүмбэрэл, Н.Найдалаа,
Т.Найдан, Н.Доржпүрэв



Дарга: Ц.Содхүү,
Гишүүд: Д.Мөнхбат, С.Энхтайван,
С.Мөнгөнсар, Б.Насанбат,
И.Даваадорж, Л.Лувсанцэрэн



Дарга: Л.Баярсайхан,
Гишүүд: С.Баярмагнай, Б.Дэлгэрбат,
Ж.Сугарсүрэн, Б.Батхуяг,
С.Энхтайван, Т.Найдан



Дарга: Р.Ганболд,
Гишүүд: Ч.Болормаа, Н.Бямбагэрэл,
В.Хүрэлбаатар, Ц.Содхүү,
Л.Лувсанцэрэн, Ж.Батсайхан

ХУРЛЫН ХОРООД



Дарга: Т.Идэрцагаан,
Гишүүд: Ч.Мягмарсүрэн,
Б.Болортунгалаг, Ж.Батсайхан,
Л.Цэеэрэгзэн, Д.Уянга, Б.Батхуяг

ХОТ БАЙГУУЛАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ГЭР ХОРООЛЛЫН ХӨГЖЛИЙН ХОРОО:

ЧИГ ҮҮРЭГ: Барилга, хот байгуулалт, дэд бүтэц, зам талбайн тохижилт, орон сууц, нийтийн аж ахуй, Гэр хорооллын хөгжлийн бодлого, төсөл хөтөлбөр, Үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалтад хяналт тавих

Хуралдааны тоо	16
Санал дүгнэлт	13



Дарга: Т.Уламбаяр,
Гишүүд: С.Мөнгөнсар,
Ж.Чимэдцогзол, Ч.Ариунчимэг,
Л.Цэеэрэгзэн, Ч.Мягмарсүрэн,
В.Хүрэлбаатар

НИЙГЭМ ЦАХИМ БОДЛОГЫН ХӨГЖЛИЙН ХОРОО:

ЧИГ ҮҮРЭГ: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хүн ам зүй, цахим мэдээллийн үйл ажиллагааг хангах, төрийн байгууллагын цахим мэдээллийн сүлжээ, системийн үйл ажиллагаа, хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, үйл ажиллагаанд хяналт тавих

Хуралдааны тоо	20
Санал дүгнэлт	19



Дарга: Б.Дэлгэрбат,
Гишүүд: Р.Ганболд, Д.Отгонбаатар,
З.Бямбажав, Ж.Булганцэцэг,
Н.Оюунгэрэл, Ч.Ариунчимэг

ЁС ЗҮЙ, ӨРГӨДЛИЙН ХОРОО:

ЧИГ ҮҮРЭГ: Иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, бүх нийтийн санал асуулга, олон нийтийн санаа бодлын тандалт судалгаа, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих

Хуралдааны тоо	18
Санал дүгнэлт	19

ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГЭМ СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР:



ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2021 ОНЫ 28 ДУГААР
ТОГТООЛ

Эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг стандартын шаардлагад нийцсэн орчин нөхцөлд, мэргэжлийн багаар, чанартай, тэгш хүртээмжтэйгээр үзүүлэн анхан болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг, иргэд олон нийт, хамт олны идэвх оролцоотойгоор сайжруулан тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх 4 зорилт бүхий “Эрүүл Чингэлтэйчүүд-2024” төсөл, арга хэмжээ амжилттай хэрэгжлээ.



Улсын төсвийн хөрөнгөөр дүүргийн 13 дугаар хороонд жишиг Өрхийн эрүүл мэндийн төв байгуулагдав.



Улсын төсвийн хөрөнгөөр дүүргийн 14 дүгээр хороонд жишиг Өрхийн эрүүл мэндийн төв байгуулагдав.



Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 2 дугаар хороонд 1-3 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төв байгуулагдав.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр 16 дугаар хороонд жишиг Өрхийн эрүүл мэндийн төвийг байгуулав.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр 10 дугаар хороонд баригдах олон улсын жишигт нийцсэн “Нэгдсэн эмнэлэг”-ийг барих газрын 55 нэгж талбарыг бүрэн чөлөөлөв.




Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах дүүргийн Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэндийн төв”-ийн барилгын ажлыг эхлүүлэв.



Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах Эрүүл мэндийн төвийн амбулаторийн барилгын өргөтгөлийн ажлыг эхлүүлэв.



Дүүргийн Эрүүл мэндийн төвд Эрэгтэйчүүдийн урологи, андрологийн тоног төхөөрөмжийг, эмэгтэйчүүдийн тасгийг тохижуулахад шаардагдах тавилга, техник хэрэгслийг тус тус хүлээлгэн өгөв.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр дүүргийн Эрүүл мэндийн төвд 376,2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг олгов.



Ковид 19 цар тахлын хүнд үед дүүргийн Эрүүл мэндийн төвд 19 төрлийн техник, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөв.



Дүүргийн Эрүүл мэндийн төв болон хороодын Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүчил төрөгчийн иж бүрэн аппарат, нярайн шарлалтын аппарат, нярайн жин, ургийн зүрхний цохилт хэмжих зэрэг 5 төрлийн иж бүрдэл бүхий тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөв.



Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд “Хороодын Өрхийн эрүүл мэндийн төвийн цахим бүртгэл, өвчний түүх, эмчийн жор, үзлэгийг мэдээллийн сан бүхий бүртгэл, мэдээллийн систем” төсөл хэрэгжив.



“Эртэч Чингэлтэйчүүд” бүх нийтийг аяныг жил бүр зохион байгуулж, давхардсан тоогоор 10,000 гаруй иргэд, төрийн албан хаагчид хамрагдлаа.



Эрүүл мэндийн чиглэлийн 93 удаагийн сургалт, өдөрлөг арга хэмжээнд дүүргийн 24145 (давхардсан тоогоор) иргэд хамрагдав.

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2024
ОНЫ 27 ДУГААР
ТОГТООЛ

Багшийн тасралтгүй хөгжил, сургалтын байгууллагын менежментийн өөрчлөлтийг боловсронгуй болгож, боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, хүүхдийн сурч, хөгжих эерэг таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх 4 зорилт бүхий “Чадварлаг багш-2024” төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууслаа.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 7 дугаар хороонд 240 ортой 291 дүгээр цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 10 дугаар хороонд 240 ортой 292 дугаар цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 16 дугаар хороонд 150 ортой 293 дугаар цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 12 дугаар хороонд 150 ортой 298 дугаар цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 5 дугаар хороонд 150 ортой 327 дугаар цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 14 дүгээр хороонд 180 суудал бүхий 145 дугаар сургууль, 120 ор бүхий 277 дугаар цэцэрлэгийн цогцолборыг шинээр барьж, ашиглалтад оруулав.





Дүүргийн Төрийн өмчийн 38 цэцэрлэгт Аймбрик, Стийм, Монтессори олон улсын хөтөлбөрүүдийг хэрэгжиж байна.



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хивс хивсэнцэр, зөөлөн эдлэлийг бүрэн шинэчиллээ.

ЦЭЦЭРЛЭГ

2021-2024 ОН



**ШИНЭЭР
БАРЬСАН - 6**



**1170 ОР
НЭМСЭН**

2021

600 ор

2022

300 ор

2023

150 ор

2024

120 ор

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 20 дугаар хороонд 149 дүгээр сургууль ашиглалтад оров.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 4 дүгээр хороонд 5 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.



Дүүргийн 61 дүгээр сургуулийн урлаг заалыг засаж, тохижуулав.



Дүүргийн 17, 24, 57 дугаар сургуулиудын хөл бөмбөгийн талбайг сэргээн засварлав.



Дүүргийн 23, 37 дугаар сургуулиудад Усан бассейн бүхий спорт заал шинээр барихаар ажиллаж байна.



Дүүргийн 37, 50 дугаар сургуулиудад ЖАЙКА олон улсын байгууллагын санхүүжилтээр шүдний эрүүл мэндийн жишиг кабинет байгуулав.



Дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын багш нарыг зөөврийн компьютероор хангав.



Дүүргийн 5, 24, 72, 140, 174 дүгээр сургууль, 327 дугаар цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хүлээлгэн өглөө.



Дүүргийн төрийн өмчийн 18 сургуульд багшийн хөгжлийн төвүүд байгуулагдлаа.



Хурлын төлөөлөгчид дүүргийн төрийн өмчит 6 сургууль, 9 цэцэрлэгийн үйл ажиллагаа, анги дүүргэлт, хамран сургах тойргийн хүртээмжид хяналт шалгалт хийв.



Япон Улсын Шизүока хотын Яйзү хоттой хамтран хэрэгжүүлж буй сурагч солилцооны хөтөлбөрт Чингэлтэй дүүргийн өсвөрийн шигшээ багийн 12 сурагчийг хамруулав.



БНСУ-ын Ёнсу дүүргийн Сунду хоттой хамтран хэрэгжүүлж буй “Сурагч солилцоо”-ны хөтөлбөрт дүүргийн 20 сурагчийг хамруулав.

СУРГУУЛЬ

2021-2024 ОН



Гэр бүл-2024
ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2024
ОНЫ 21 ДҮГЭЭР
ТОГТООЛ

Гэр бүлийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, гэр бүлийн боловсрол олгох замаар амьдралын чанарыг сайжруулах, тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэхэд салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, гэр бүлтэй ажиллах ажилтнуудыг чадваржуулах, хамтарсан багийн идэвх оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах 3 зорилт бүхий “Гэр бүл-2024” төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууслаа.



Дүүргийн иргэд, залуу төрийн албан хаагчдад гэрлэлтийн гэрчилгээ гардуулах ёслолын арга хэмжээг зохион байгуулж, 58 хос хамрагдав.



Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд Эцэг эхийн зөвлөлийг байгуулав.



Эрэгтэйчүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх жишиг төв байгуулагдлаа.



Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийг байгуулав.



Гэр хохирогчийг түр хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төвд автомашин хүлээлгэн өгөв.



Дүүргийн “Гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв”-д номын сан байгуулав.



Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг Дэлхийн өдрийн хүрээнд “Шийтгэл бол шийдэл биш” аяныг зарлаж, олон жил бүр зохион байгуулж хэвшлээ.



Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор жил бүр шилдэг хамтарсан багийн уралдааныг зохион байгуулж хэвшлээ.



“Хүүхдэд ээлтэй сургууль”, “Анхаар хүүхэд-хариуцлагатай эцэг эх”, “Хүүхдэд ээлтэй жолооч”, “Гэр бүлийн хүчирхийлэлгүй Чингэлтэй” өдөрлөг, аян, төсөл арга хэмжээг зохион байгууллаа.



Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр зохион байгуулсан 54 удаагийн арга хэмжээнд 3891 иргэн хамрагдав.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР:




ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2024
ОНЫ 31 ДҮГЭЭР ТОГТООЛ

Эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг стандартын шаардлагад нийцсэн орчин нөхцөлд, мэргэжлийн багаар, чанартай, тэгш хүртээмжтэйгээр үзүүлэн анхан болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг, иргэд олон нийт, хамт олны идэвх оролцоотойгоор сайжруулан тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх 4 зорилт бүхий “Эрүүл Чингэлтэйчүүд-2024” төсөл, арга хэмжээ амжилттай хэрэгжлээ.



Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 24 иргэн 20-80 хувийн хөнгөлөлттэй түрээсийн ажлын байраар хангагдав.



2020-2024 онд 90 бойжигчийг Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих төвөөр дамжуулан чадавхжуулав.



2020-2024 онд дүүргийн 295 үйлдвэр эрхлэгчийг 7,5 тэрбум төгрөгийн зээл, төсөл хөтөлбөрт хамруулав.



Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 1063 иргэн, үйлдвэрлэгчдийг 55 удаагийн үзэсгэлэн худалдаанд хамруулж, 2 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг борлуулав.



2020-2024 онд дүүргийн 2482 иргэнийг ажлын байранд зуучилж, 11374 иргэн, аж ахуй нэгжид хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлэв.




2020-2024 онд дүүргийн 207 иргэнийг 1,4 тэрбум төгрөгийн ажлын байрыг дэмжих санхүүгийн дэмжлэгт хамруулав.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:



ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2021
ОНЫ 30 ДУГААР
ТОГТООЛ

Байгальд ээлтэй эко санал санаачилгыг нэвтрүүлж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг бий болгох, түүнийг арчлах, агаар хөрсний бохирдлыг багасгах, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 2.8м²-аас дээш хувьд хүргэн нэмэгдүүлэх замаар ирээд, олон нийтэд экологийн боловсролыг төлөвшүүлж, ногоон хөгжлийг дэмжих 6 зорилт бүхий “Ногоон дүүрэг-2024” арга хэмжээг хэрэгжүүлээ.



Дүүргийн хэмжээнд 11,709 гэрэлтүүлгийн 98,5 хувь нь бүрэн асалттай байна.



“Хашаандаа мод тарья” аяныг зарлаж, 18640 мод бут, сөөг тарьж ургуулав.



Хашаандаа мод тарья аяны хүрээнд дүүргийн иргэдэд “Тарья, арчлая, услая, ургуулъя” сургалтыг зохион байгуулав.



Ногоон дүүрэг арга хэмжээний хүрээнд 2020-2024 онд 34,160 м.кв талбайд зүлэгжүүлэлт хийгдэв.



Улс, нийслэл, дүүргийн төсвийн 2.7 тэрбум төгрөгөөр дүүргийн 12 байршилд бичил цэцэрлэг, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэв.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр 16 дугаар хорооны Хайлаастын замаас Хайлаастын эцэс хүртэл 710 метр авто зам тавив.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр 17 дугаар хорооны Сурагчийн 24 дүгээр гудамжинд 150 метр авто замыг тавив.



Дүүргийн 12 дугаар хороо Дэнжийн 1000-ын цагаан байрны уулзвараас Хүчит шонхор захын уулзвар хүртэл 1670 метр авто замын өргөтгөл хийв.




Дүүргийн хэмжээнд сул шороон хөрс бүхий 72,691 м.кв талбайд асфальт, байгалийн чулуун, бетонон хучилттай нийт 3,2 км авто зам тавив.



Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр Зурагтын эцсээс дүүргийн 7 дугаар хороо хүртэлх авто замыг амжилттай засварлав.

АВТО ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН АВТО ЗАМ (УРТ МЕТР)




2020 ОН

2021 ОН

2023 ОН

2024 ОН

Дүүргийн нутаг дэвсгэрт 2020-2023 онд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар



авто замын байгууламж шинээр хийгдсэн.




Хог хаягдлыг ангилан ялгаж, байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн “Чингэлтэйн хог баялаг болно” төслийг хэрэгжүүлэв.



Энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх үйлчилгээний хураамжийн хэмжээг өрх бүрээр тооцох шийдвэрийг батлан, хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэв.



Чингэлтэй хайрхан уулын салбар уулс орчмын хилийн цэсийн солбицлыг шинэчлэн тогтоож, нийт 2.784.57 га газрыг газрын кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулав.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дүүргийн 16 дугаар хорооны Согоотын 26, 40 дүгээр гудамжны 222 айл өрхийг цэвэр, бохир усны шугамд холбох ажлын зураг төсвийг дүүргийн төсвөөр хийж гүйцэтгэв.



8, 9, 10, 17, 23, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн нийт 206 нэгж талбарыг дүүргийн төр захиргааны байр, эрүүл мэндийн төв, хорооны цогцолбор байр, сургууль, цэцэрлэг барих зориулалтаар чөлөөлөв.



Газрын зөрчил, маргаан бүхий дүүргийн нутаг дэвсгэр дэх 35 байршлын 362 объект, 153 байршлын 6757 метр хашаа хайсыг тус тус бүрэн чөлөөлж, газрын зөрчлийг арилгав.

ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:



ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2021
ОНЫ 33 ДУГААР
ТОГТООЛ

Иргэдийг аюулгүй амьдрах ухаанд сургах, гамшгийн эмзэг байдал эрсдэлийг бууруулах 3 зорилт бүхий Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулах гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх-2024 арга хэмжээг хэрэгжүүлэв.



Гамшгийн эрсдэлийг бууруулах Чингэлтэй дүүргийн зөвлөлийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд байгуулав.



Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн гишүүдийг шинээр бүртгэлжүүлж, таних тэмдэг бүхий ажлын хувцас хэрэглэлээр хангав.



Дүүргийн Ерөнхий боловсролын сургууль бүрд “Өсвөрийн аврагч” бүлгэмийг байгуулав.



Япон Улсын Шизуока мужийн Яйзү хотоос бэлэглэсэн 1,5 тонн усны танкны багтаамжтай гал түймэр унтраах автомашиныг дүүргийн Онцгой байдлын хэлтэст хүлээлгэн өгөв.



Дүүргийн онцгой байдлын хэлтэст дизель хөдөлгүүр, автомат удирдлага бүхий ус зайлуулах насосыг хүлээлгэн өгөв.




Дүүргийн 1-24 дүгээр хороодод бохирын ус зайлуулах насосыг хүлээлгэн өгөв.



Гамшгийн зөвлөлийн төсвөөс дүүргийн Чингэлтэй Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ-т ус зайлуулах насос худалдан авахад дэмжлэг үзүүлэв.



Дүүргийн төрийн өмчит Ерөнхий боловсролын 19 сургууль, 37 цэцэрлэг, 24 хороодод анхны тусламжийн иж бүрдлийг хүлээлгэн өгөв.



Гамшгийн эрсдлийг зарлан мэдээлэх дуут дохиог дүүргийн 15, 16 дугаар хороодын нутаг дэвсгэрт байрлуулав.



Дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Улаан загалмайн хороонд техник, хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэв.



Үер усны гамшигт өртсөн дүүргийн 110 өрхөд эд материалын болон хүнсний тусалцаа үзүүлэв.



Дүүргийн зорилтод бүлгийн 200 өрхөд “Нэг өрх-нэг гал унтраагуур” практик дадлага олгох үйл ажиллагааг зохион байгуулж, гал унтраагуурыг хүлээлгэн өгөв.



Гамшгийн эрсдэлийн үнэлгээг дүүргийн 142 объектод хийж гүйцэтгэв.



Гамшгаас хамгаалах мэдлэг дадлага олгох 438 удаагийн сургалтад 10669 иргэд хамрагдав.

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:



Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах сабар зөвлөлийн төсвөөр дүүргийн 17, 37, 39, 57, 72, 5, 50, 24, 49, 61, 139 дүгээр сургуульд “Итгэлтэй утас” суурилуулж, хүүхдүүд эцэг эхтэйгээ үнэ төлбөргүй холбогдох боломжтой боллоо.




“Эцэг эхчүүд, өсвөр насны хүүхдүүдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх нь” төслийг зорилтот гэр бүлийн дунд хэрэгжүүлэв.



Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Ногоон бүс” төслийг хэрэгжүүлж, 24 хорооны 848 цэгт 2633 камерыг байрлуулав.




Дүүргийн 16 дугаар хороонд нэг дор 800 ширхэг камерын дэлгэцийг нэгтгэн харах камерын хяналтын төв шинээр байгуулагдав.



Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсвөөр дүүргийн 37, 39, 43, 72, 139, 149 дүгээр сургуулиуд, 43, 221, 293, 298 дугаар цэцэрлэгүүдийн гадна, дотно орчныг камержуулав.



Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах сабар зөвлөлийн төсвөөр дүүргийн 49 дүгээр сургуулийн орчмын авто зам дээр хурд сааруулагч тавив.




Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсвөөр 24, 37, 49, 57, 138, 139, 140, 149 дүгээр сургуулийн ойролцоох авто зам дээрх явган зорчигчийн гарцад тусгах лед гэрэлтүүлэг суурилуулав.



Дүүргийн Цагдаагийн газарт дрон, энгэрийн камер хуулагч, чанга яригч цагаан хоолой, цахилгаан скүтер зэрэг тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэв.



Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах үйл ажиллагаанд туслах чиг үүрэг бүхий сайн дурын 672 иргэн ажиллаж байна.




Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудыг ажиллах нөхцөлийг сайжруулж, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж байна.



Дүүргийн сайн дурын иргэдийн зөвлөл, нийтийн эргүүлийн үйл ажиллагааг эхлүүлсний 10 жилийн хүрээнд өдөрлөг, арга хэмжээ зохион байгууллаа.

ГАДААД ДОТООД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:





Бүгд найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Манжуур хотод Чингэлтэйд үйлдвэрлэв төвийг, Чингэлтэй дүүрэгт “Манжуурын бараа бүтээгдэхүүний төв”-ийг нээх чиглэлээр санамж бичиг байгуулав.



Бүгд найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын өөртөө засах орны Манжуур хотод 45 үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлууллаа.



Япон Улсын Шизуока мужийн Яйзү хоттой гамшиг, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.



Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Грийн эмнэлэгтэй Хурлын эмэгтэй Төлөөлөгчид дүүргийн зорилтот бүлгийн хүүхдэд үзлэг, оношилгоо, эмчилгээ хийх чиглэлээр хамтран ажиллахаар болов.



Бүгд Найрамдах Солонгос Улсын Чезү хоттой аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр харилцаа тогтоов.



БНТУ-ын Анталая хотын Кемер дүүрэгтэй харилцаа тогтоож хамтран ажиллах чиглэлийг тогтоов.



Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим болон ОХУ-ын Улаан-үд хотын Байгаль экспотой хамтран “Монгол-Оросын хамтарсан Олон Улсын үзэсгэлэн худалдаа”-г “Тусгаар тогтнолын талбай”-д зохион байгуулав.



“Дэээрэт” Олон Улсын энэрлийн байгууллагатай хамтран 354,5 сая төгрөгийн өртөг бүхий хүнсний болон эд материалын хандив, тусламжийг дүүргийн зорилтод бүлгийн айл өрхүүдэд хүргүүлэв.





Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Ж.Самбуугийн гудамж-16
www.chingelteicouncil.mn
www.chingeltei.ub.khural.mn
Утас: 11-310193
Факс: 11-310194
Цахим шуудан: ith_office@chingelteicouncil.mn